

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ  
08 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Засгийн газрын 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Харилцаа холбоо мэдээлэл технологийн газартай хамтран 23 сум 1 тогсонд операторийн үйлчилгээг үзүүлж 54 төрлийн лавлагааг олгож байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх "Хөгжлийн хөтөч" үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгээр сэтгүүл бэлтгэж хэвлэлтэд өгөхөд бэлэн боллоо.

**Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2020 оны 08-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 6.2 тэрбум төгрөгний **1,189** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 8-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 6,532.8 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 7,650.8 сая төгрөг буюу 117.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 89,815.1 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 44,734.8 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 36,219.3 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 1,634.5 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 4,634.9 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 89,815.1 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 79,606.0 мянган төгрөг буюу 86.6 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,704.7** сая төгрөг өмнөх сараас **83.2** сая төгрөгөөр буурсан байна.

Нийт өглөг **1,015.9** сая төгрөг өмнөх сараас **120.9** сая төгрөгөөр өссөн байна.

2020 оны 08 дугаар сарын байдлаар нийгмийн даалтгалын санд шимтгэлийн орлого 2580.7 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 37.3 сая төгрөгийн, шимтгэлийн орлого, 88.1 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2598	2270.1	87.4
Тэтгэмж	223.8	210.2	93.9
Үомшө	99.2	90.7	91.4
ЭМД	0,0	0,0	0,0
Ажилгүйдэл	50.1	47	93.8
дүн	2971.1	2618	88.1

Тэтгэврийн даатгалын сангаас 19568 тэтгэвэр авагчид 6545.4 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 351 даатгуулагчаас 226,6 сая тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 80 даатгуулагчдад 27.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 661.3 сая төгрөг байна.

Санхүү хяналт дотоод аудитын шалгалтыг 2020 оны 9-р сарын байдлаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дагуу 124 байгууллагад хяналт шалгалт хийсэн ба аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу орон нутгийн орлого бүрдүүлэлт, аймгийн Засаг даргын Тамгын газар, Төмөрбулаг сумын төсөвт байгууллагуудад хяналт шалгалт хийгдэж байна.

Дотоод аудитын явцад 56 танилцуулга, тайлан бичиж, 296,533 мянган төгрөг төлүүлэх 72 акт тогтоон, зөрчил арилгуулах 19 албан шаардлага тавьж зөвлөмж өгч ажиллав.

### **Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :**

#### Хяналт шалгалтын чиглэлээр

Хөвсгөл аймагт их хэмжээний аадар бороо орсны улмаас Мөрөн сумын зүүн талаас орж байгаа авто замын хэвтээ тэнхлэгийн уулзвар, 1, 6, 7,13, -р багийн Айл өрх цахилгаан дамжуулах дэд станц албан байгууллагуудын падвол үерт авагдсан байна. Мөрөн сумын Засаг даргын Тамгын газартай хамтарсан ажлын хэсэг үерт орсон газруудын нөхцөл байдалд хяналт хийж үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, эд хөрөнгө аюулгүй байдлаа хангаж хамгаалах чиглэлээр зөвлөгөө өгч хөрсний 11 цэгээс дээж авч шинжилгээнд хамруулахад нянгийн бохирдолтой гарсан байна.

Ариутгал халдваргүйтгэл хийх бодисыг шинжлүүлж халдваргүйтгэлийн ажлыг Мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр бэлтгэлийг хангаж байна.

Мөн Хатгал тосгоны чиглэлийн авто замы үерт тасарсаныг Хөвсгөл АЗЗА ХХК сэргээн засварлсан. Хилэнтийн гүүр чиглэлийн төв замыг засварын ажил хийгдэж байна.

Аялал жуулчлал эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор цахим орчинд үер усны аюул зам тээврийн осол эндлээс урьдчилан сэргийлж, эрдсэлгүй амрах аялахыг уриалсан 10 гаруй постер, ойн дагалдах баялаг, хуш модны самрыг урьдчилан бэлтгэж түүхгүй байх болц гүйцсэн үед нь байгаль хамгаалагчийн зөвшөөрлөөр түүж бэлтгэх талаар анхааруулга сэрэмжлүүлэгүүдийг постолж иргэдэд мэдээ мэдээлэл түгээсэн байна.

Цэцэрлэг, Цагаан уул, Арбулаг, Шинэ-Идэр зэрэг сумд таравган тахлын голомттой бөгөөд Тарвага агнахыг хориглосон шийдвэр цуцлагдаагүй байхад тарвага агнахгүй байх, хот суурин газарлуу тарваганы мах тээвэрлэхгүй байхыг иргэдэд анхааруулсан, мэдээ мэдээлэлийг тогтмол бэлтгэн түгээж, сумдын байгаль орчны байцаагч холбогдох мэргэжлийн хүмүүс хүн ихээр төвлөрсөн газруудад зөвлөмж бэлтгэн хүргүүлээ. Мөн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран хийж байна.

Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Цагдаагийн байгууллагуудын хамтарсан аялал жуулчлалын бүс нутаг дахь хүүхэд хамгаалал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх "Нэгдүгээрт хүүхэд" аяныг эхлүүлэн хэрэгжүүлж байна.

-Аяны хүрээнд 300 ширхэг гарын авлага бэлтгэж хүүхэд эцэг эхчүүдэд тарааж, Мөрөн, иХатгал, Алаг-Эрдэнэ сумын чиглэлийн замын том самбаруудад сэрэмжлүүлэгүүдийг аноноосоор байршуулсан. Мөн тоглоомын талбайн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллагатай хамтран хангуулж ажиллаа.

**Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

## **ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛУУД**

Нэг цэгийн үйлчилгээний төв нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан чиглэлийн дагуу 24 цагийн турш, бичиг баримт, харьяалал харгалзахгүйгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан үйлчилгээг иргэд, хүүхдэд үзүүлдэг. Газрын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д дараах байдлаар үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- Холбон зуучлах үйлчилгээ нийт 8, насанд хүрэгч 5, хүүхэд 3
- Эрүүл мэндийн үйлчилгээ нийт 8, насанд хүрэгч 5, хүүхэд 3
- Гэр бүлд эргэн нэгтгэгдсэн нийт 6, насанд хүрэгч 2, хүүхэд 4
- Хууль, эрх зүйн зөвлөгөө нийт 8, насанд хүрэгч 3, хүүхэд 5
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ нийт 8, эрэгтэй 3, эмэгтэй 5
- Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ нийт 31, насанд хүрэгч 20, хүүхэд 11

- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ нийт 9, насанд хүрэгч 1, хүүхэд 8 хүн байрлаж хамгааллын үйлчилгээ авсан байна.

Төвийн 70382121 утсыг 24 цагаар тогтмол ажиллуулж, 3 дуудлагыг аймгийн Цагдаагийн газар холбон зуучилж ажиллалаа.

Нэг цэгийн үйлчилгээний төвийн албан хаагчдад коронавирүсээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийг тухай бүр өгч, туслах багш 2 цаг тутамд цэвэрлэгээ ариутгал халдваргүйжүүлэлт хийн эрүүл мэндийн ажилтан хяналт тавин ажиллаж байна. Иргэдийг үйлчилгээ авахдаа амны хаалттай байхыг зөвлөн ажиллаж байна.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлж буй хүүхдүүдэд нас сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар үлгэр зохиох дасгал, логик сэтгэхүй хөгжүүлэх, сэтгэн бодох, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулж байна.

### “ГЭР БҮЛД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨВ”-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2020 оны 7-р сарын 27-оос 8-р сарын 20-ны өдрийн байдлаар гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр нийт 14 насанд хүрэгч, 9 хүүхэд нийт 23 хүнд 27 удаагийн сэтгэл зүй, хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлсэн байна.

Төвөөр дамжуулан дараах үйл ажиллагаа бүхий үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Шинээр гэр бүл болж буй залуусыг шинжлэх ухааны үндэслэлтэй шаталсан сургалтанд хамруулж гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийн талаар зөв үзэл хандлага, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлж, гэрлэлтийн гэрчилгээг олгоход чиглэсэн ажлыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д байрлаж буй 01 кэйсийн “С”, “А”, “С” нарт бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг тус тус 1 удаа үзүүлсэн байна.
- “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв” фэйсбүүк хуудсанд төвийн үйл ажиллагааны танилцуулга, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг сурталчилан байршуулж, 1545 хүний хандалт авсан байна.

### ХҮҮХДИЙН ТУСЛАМЖИЙН 108 УТАСНЫ МЭДЭЭЛЭЛ

Хүүхдийн тусламжийн утас-108-д ирсэн дуудлагыг хүлээн авч, анхан шатны бүртгэлийг хийж, холбогдох мэргэжилтнүүдэд хүргэн ажиллаж байна. 2020 оны 8 сард нийт 5 дуудлага ирсэн байна. /Мөрөн сум – 1, Хатгал тосгон -2, Түнэл сум- 1, Ханх сум-1/

- Сумдтай холбоотой дуудлага мэдээллийг сумд руу хүргүүлж нийгмийн ажилтан, хариуцсан ажилтнуудтай холбогдож ажиллаж байна.
- Нэгдсэн эмнэлэгийн хүүхдийн тасгаас тархины саажилттай хүүхэд хараа хяналтгүй байна гэх дуудлагын дагуу хүүхдийн эрсдэлийн үнэлгээ, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж багийн засаг даргад холбон зуучилсан.
- Нэгдсэн эмнэлэгийн төрөх эмэгтэйчүүдийн тасгаас 17 настай хүүхэд төрсөн гэх дуудлагын дагуу хүүхдийн эрсдэлийн үнэлгээ, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, аймгийн Цагдаагийн газарт мэдээллэсэн.

## ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ЗАЛУУЧУУДАД АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр жил бүрийн 8 дугаар сарын 12-ны өдрийг “Олон улсын залуучуудын өдөр” болгон тэмдэглэхээр тунхагласан. Монгол улсын хувьд энэхүү уриалгыг дэмжиж Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь хэсэгт “Залуучуудын өдөр”-ийг 8 дугаар сарын 25-нд тэмдэглэхээр заасан. Энэ жил залуучуудын хөгжлийн сарын хүрээнд Залуучуудын нийгэмд оруулж буй хувь нэмрийг таниулах, залуучуудын хөгжил, тулгамдаж буй асуудлын шийдэл, боломжийг эрэлхийлж бодит оролцоог дэмжих зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлах, залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан залуусын оролцоог хангах, тэдний гэр бүлийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн залуучуудыг дэмжих зорилгоор зорилтот бүлгийн залуучуудад амьдрах ухааны сургалтыг зохион байгуулав.

Уг сургалтыг 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдөр хүүхдийн ордны 209 тоотод зохион байгуулсан ба ЗХТ-ийн мэргэжилтэн Д.Батцэнгэл “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлах”, “Залуучуудын хөгжлийн төвийн танилцуулга” ЗХТ-ийн мэргэжилтэн Г.Баасансүрэн “Стресс түүнийг тайлах нь” ЗХТ-ийн мэргэжилтэн Л.Отгончимэг “Хувь хүний хөгжил” Гэр бүл, хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн Ц.Бурмаа “Гэр бүлийн харилцаа” Гэр бүл, хүүхдийн эрхийн хэрэгжилт хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ц.Нарангэрэл “Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар” гэсэн сэдвүүдээр зорилтот бүлгийн 18-35 насны 56 залуучууд хамрагдлаа.

## “ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-Т ХАМРАГДДАГ ӨРХҮҮДИЙН ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙГ ЗУСЛАНД АМРААВ.

Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан залуусын оролцоог хангах, зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд “Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж буй өрхийн хүүхдүүдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-т хамрагддаг өрхүүдийн өсвөр насны хүүхдүүдэд зориулсан зуслангийн хөтөлбөрийг зохион байгуулав.

Уг үйл ажиллагааг 2020 оны 8 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд аймгийн “Уран дөш” зуслан дээр зохион байгуулсан ба “Залуучуудын хөгжилд бидний оролцоо” өртөөчилсэн хөтөлбөр, “Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгуулж 95 хүүхэд хамрагдав.

Үйл ажиллагааны үр дүнд хүүхдэд мэргэжил сонголтын талаар үндсэн ойлголт, мэргэжил сонголтын тест, мэргэжил сонголтын талаар зөвлөгөө мэдээлэл, залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн талаарх ойлголт, хорт зуршилын үр дагавар, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, залуусын эрхэмлэх зүйлсийн талаар гэсэн ойлголтуудын талаар шинэ мэдлэг мэдээлэлтэй болов

## **Эрүүл мэндийн чиглэлээр:**

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЛЭЭ.**

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд Галт, Жаргалант, Рашаант, Төмөрбулаг, Тосонцэнгэл сумдын Эрүүл мэндийн төвүүд, Их-Уул сумын Сум дундын эмнэлэгт “Мобайл технологи” буюу хөдөлгөөнт эрүүл мэндийн технологийг нэвтрүүлэх тоног төхөөрөмжийг 9 нэр төрлийн хавдрын хурдавчилсан оношлууруудын хамт хүлээлгэн өглөө. Мөн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нярайн фото шарлагын аппарат, белиметр, ургийн монитор, сэргээн засах аппарат, мэдээлэл технологийн хэрэгсэл зэрэг 35 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг Мөрөн сумын 5 өрхийн эрүүл мэндийн төвд гардуулан өглөө. Ингэснээр сумдын эмч мэргэжилтнүүд чадавхижиж сумын иргэд 2 догч шатлалын тусламж үйлчилгээ оношлогоо эмчилгээг өрх сумаас авах бүрэн боломжтой боллоо.

### **-МАНАЙ АЙМГИЙН ИРГЭД СУДАЛГААНД ХАМРАГДАХААР БОЛЛОО.**

Зүрхний дутагдлын оношлогоо, эмчилгээ, хяналтын цогц менежментийг бий болгох зорилго бүхий “Монгол Улсын хүн амын дундах зүрхний дутагдлын тархвар зүйн судалгаа”-г Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг болон судалгаанд хамрагдаж буй Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгууллаа. Уг судалгаанд аймгийн хэмжээнд 300 иргэнийг хамруулах бөгөөд одоогоор Мөрөн сумын 1,2, 9,10,11,14 дүгээр багийн 100 иргэнийг хамруулаад байна. Цаашид Тосонцэнгэл сум, Хатгал тосгоны иргэдийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

### **-ЭМНЭЛГҮҮД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД ХАМРАГДЛАА.**

Эрүүл мэндийн байгууллагуудын хүсэлтээр Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс томилогдсон магадлан итгэмжлэлийн шинжээч эмч нар 8 дугаар сарын 21-28 өдрүүдэд орон нутагт ирж Эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжлэлд хамруулах үнэлгээг хийж, ЭМБ-дад ажиллалаа. Ажиллах хугацаанд Баянзүрх, Ханх, Түнэл, Рашаант сумдын Эрүүл мэндийн төв, Шинэ-Идэр сумын Сум дундын эмнэлэг, “Хүмүүн” хувийн эмнэлэгүүд тус тус хамрагдаж амжилттай үнэлгээ авсан байна.

### **-ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТЫГ ДЭМЖИХ 7 ХОНОГИЙН АЯН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.**

Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих Дэлхийн долоо хоногийн аяныг тэмдэглэн өнгөрүүлэх тухай удирдамжийг Эрүүл мэндийн газрын 2020 оны 773 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажилласан ба эрүүл мэндийн байгууллага бүр үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж байгууллагын дарга баталгаажуулан хэрэгжүүлж ажиллалаа. Хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээс харахад 17 Эрүүл мэндийн байгууллага “Нялх, балчир насны хүүхдийн хүнсний тухай хууль” болон Эрүүл мэндийн сайдын А/290 дугаар тушаал, “Эхийн

сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхмыг хэрэгжүүлэх заавар” сэдвүүдээр эмч эмнэлгийн ажилтнууддаа дотоодын сургалт зохион байгуулсан байна. Мөн 705 Аж ахуй нэгжид “Нялх, балчир насны хүүхдийн хүнсний тухай хууль” болон Эрүүл мэндийн сайдын А/328 дугаар тушаал “Нялхсын болон хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хоол, хооллох хэрэгслийн сав баглаа боодол, шошгын тухай журам, үлгэрчилсэн заавар”-ын талаар мэдээлэл өгсөн байна. Орон нутгийн 2 мэдээллийн хэрэгслэлээр Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч Эхийн сүүний ач холбогдол, ашиг тусын талаар зөвлөгөө, мэдээллийг өгсөн. Уг мэдээлэл 7 хоногт 4 удаа, өдөрт 2 нийт 8 удаагийн давтамжтай цацагдсан. Мөн бүх Эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар дамжуулан 10 төрлийн постер, инфографик, шторк ашиглан иргэдэд мэдээлэл өгсөн. Нийт 3565 удаагийн хандалт авсан байна.

### **Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын ажил олгогч эздийн холбоо, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол сургалт, залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн зөвлөлүүдийн хамтын ажиллагаа” сэдэвт уулзалтыг 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Тус уулзалт, хэлэлцүүлэгт аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, Мэргэжлийн боловсрол сургалтын зөвлөл, Залуучуудын зөвлөлийн гишүүд болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, аймгийн Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв зэрэг байгууллагуудаас нийт 51 хүн оролцлоо.

**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД” ФОКУС ЯРИЛЦЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАВ.**

Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах 2018-2022” төслийн үйл ажиллагаа 2020 оноос орон нутагт эхэлж байна.

Өнөөдрийн байдлаар тус төслийн хүрээнд хөгжлийн төвийн барилгын зураг төсөв гаргах, техникийн нөхцөлийн дүгнэлт гаргах ажлууд хийдэж байгаа бөгөөд Азийн хөгжлийн банкны төслийн менежер, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны ажилтнууд манай аймагт ирж ажиллалаа.

Төслийн үр дүнгийн суурь болон төгсгөлийн судалгаа хийх ажлыг Хүний хөгжил судалгаа сургалтын төв” гүйцэтгэж манай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс дараах судалгааг авсан. Үүнд:

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 100 өрхөөс амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа,

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй бизнесийн орчныг бүрдүүлж буй 15 аж ахуйн нэгжээс судалгаа,

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар хөгжлийн бэрхшээлтэй хүний сэтгэл ханамжийн судалгааг тус тус авсан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан туслгамдаж буй асуудлууд, аймгийн хэмжээнд хийж хэрэгжүүлж буй ажлууд, сайн жишээний талаар фокус ярилцлага хийж, цаашид төслийн хүрээнд хийгдэх арга хэмжээнд санал авснаар тус арга хэмжээ дууссан.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр тушаалын хүрээнд Аймгийн Онцгой комиссын 3-р хуралдаанаар орон нутгийн хэмжээнд үүссэн нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, ард иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор шуурхай штаб байгуулан ажиллах үүрэг даалгаврыг агентлаг, сумуудын удирдлагуудад үүрэг болгон аймгийн Засаг даргын 2020 оны 82 дугаар захирамж гарсан. Үүний дагуу газрын даргын 02 сарын 16-ны А/05 тушаалаар байгууллагын штаб байгуулах тухай, А/06 тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай, А/07 тушаалаар байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх тухай тушаалуудыг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:**

2020.08.11-ээс Тариалан, Хатгал, Арбулаг, Улаан-Уул, Цагааннуур сумдад төслийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд ЖДҮХ санд 4,1 тэрбум төгрөгний санхүүжилт хүссэн 44 төслийг хүлээн авч зааврын дагуу программд оруулсан. Эдгээр төслүүдээс иж бүрдэл дутуу 2, үйл ажиллагааны чиглэл зөрсөн 5 төсөл хасагдаж 37 төсөл үлдсэн.

2020.08.10-аас 15-ны хооронд ЖДҮХ Сангийн мэргэжилтэн Б.Дашхүү, Д.Мянган нарын хамт хөнгөлөлттэй зээл хүссэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцсан. Үүнд: Тариалан сумын “Өвлийн хүлэмж”, “Хоргын өндөр”, “Дөлгөөн нутаг”, Их-Уул суманд “Хөргүүртэй махны зоорь”, Арбулаг сумын “Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл”, Баянзүрх сумын “Өргөн бэлтэс” ХХК-ийн Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл, Улаан-Уул сумын “Буянт шишгэд” ХХК-ийн Жуулчны отго төсөл, Цагааннуур сумын “Уудам Эх” ХХК-ийн Жимс боловсруулах төслүүдийг газар дээр нь танилцан судалгаа тайлбаруудыг авч заавар зөвлөмж өгч ажилласан.

2020 оны 08 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Өмнөговь аймагт зохион байгуулагдсан “Говийн бүсийн хүнсний ногооны үр үйлдвэрлэл, сорт сорилт, эмийн



ургамал, жимс, жимсгэний суулгац үржүүлэг, тариалах, арчлах, хураах технологи” сэдэвт танхимийн болон талбайн үзүүлэх сургалтанд газар тариалан хариуцсан мэргэжилтэн оролцсон.

Ургацын Баланс тогтоох ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Ургацын урьдчилсан балансаар нийт 16431га талбайд үр тариа тарьж 16181га талбайгаас 20593 тн буюу нэгжийн ургац 12,5 цн, үүнээс улаанбуудай 16140га-д тарьж 15640га-аас 20332 тн буюу нэгийн ургац 13 цн авахаар төлөвлөж байна.

2020 оны зуншилгын мэдээллийг 23 сум 1 тосгоны 129 багаас авч нэгтгэсэн. 2020 оны 08 дугаар сарын 28-ны байдлаар Хөвсгөл аймгийн хэмжээн 57 багт зуншлага сайн Цагаан-Үүр сумын Дархинт баг зуншлага муу, бусад 71 багт зуншлага дундаж хэмжээтэй байна. Хадлангийн гарц 5 багт сайн, 37 багт зуншлага муу, бусад 87 багт зуншлага дундаж хэмжээний байна. Аймгийн хэмжээнд 44,1% зуншлага сайн, 0,78 % зуншлага муу, 55,12% зуншлага дундаж хэмжээний байна. Мөн аймгийн хэмжээнд хадлангийн гарц 3,9% сайн, 28.6% хадлангийн гарц муу, 67,5% хадлангийн гарц дундаж хэмжээний байна.

Малчдад өгөх гар тэжээл бэлтгэх зөвлөмж боршурыг бэлтгэж боловсруулсан.

Аймгийн Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай А/387 тоот захирамжийн дагуу 2020-2021 онд малчид, иргэдийн хүчээр байгалийн хадлан 202624 тн, бэлтгэх албан даалгатай үүнээс: 27927 тн өвс, гар тэжээл 11, давс, хужир шүү 329 тн, ногоон тэжээл 40.0 тн тус тус бэлтгэсэн 13.8 хувьтай байна.

Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох, Төмөрбулаг суманд отрын бүс нутгийн хил заагийг баталгаажуулах газрын нэгдмэл санд оруулах ажлын хүрээнд ХХААХҮЯамны ажлын хэсэг, аймгийн ГХБГазартай хамтран судалгааг нэгтгэж ажилласан.

ОНХСангийн хөрөнгөөр Шинэ-идэр суманд 3 худаг, УТХөрөнгөөр Галт суманд 3 худаг, Жаргалант суманд 2 худгийг өрөмдсөн байна. Худгийн гүйцэтгэлийн мэдээг авч хяналт тавьж ажиллаж байна.

Ноосны урамшууллын баримт материалыг хүлээн авч программд оруулж байна. Одоогоор 15 сумын 5543 малчин өрхийн мэдээлэл ирсэн байна.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын баталсан шинжилгээ хийж гүйцэтгэх ажлын гэрээний дагуу малын гоц халварт шүлхий өвчний халдварыг тандан илрүүлэх, эрүүлийг баталгаажуулах зорилгын хүрээнд тандалтын дээж цуглуулах ажлыг Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох, Галт, Эрдэнэбулган сумдад зохион байгуулж ажиллаа. Үүнд 4 сумын 8 багийн 60 өрхийн 900 малаас цусны дээжийг цуглуулж, шинжилгээ хийх бэлтгэл хангаад байна.

Аймгийн Засаг Даргын А/313 дугаар захирамжын хүрээнд азарганаас бусад хээлтүүлэгч 31456 малд бруцеллөз өвчний тандалт шинжилгээг хийх ажлын хүрээнд 23513 малыг хамруулж 74,7 хувийн гүйцэтгэлтэй.

Аймгийн дүнгээр 13 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 1487,7 мянган толгой мал хамрагдахаас өнөөдрийн байдлаар 1209.0 мянган толгой мал хамрагдаж гүйцэтгэл 81.2 хувьтай байна.

Иргэд, хуулийн этгээдээс санхүүжүүлэх 3 нэрийн өвчний дархлаажуулалтанд 54.0 мянган толгой мал хамруулахад шаардагдах 6,5 сая төгрөгний вакцин татан авахаар төлөвлөж 2020 оны 2 дугаар сарын 13 өдрийн №2020/01/01 дугаартай “Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, биобэлдмэл нийлүүлэх” гэрээний дагуу 3 төрлийн вакцин татан авч аймгийн Засаг даргын 2020 оны А/129 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 40,0 мянган толгой мал хамрагдаж гүйцэтгэл 74,0 хувьтай хийгдэж,

Архангай, Булган аймгаас мал, мах, мал амьтны гаралтай түүхий эдийг суманд нэвтрүүлэхгүй байхад хяналт тавьж, малчид мал бүхий иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл, гарын авлага 500ш олшруулан хүргүүлж мэдээллээр ханган ажилласан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020.07 дугаар сарын 20ны өдрийн 182 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020.07.24 ний өдрийн А/389 дүгээр захирамжаар бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 1400,0 мянган охин тугал, хурга, ишгийг хамруулахаас 2020.08.25ны байдлаар 500,0 мянган толгой төл малыг хамруулж гүйцэтгэл 35,7 хувьтай хийгдэж байна.

**Зургаа.Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

Магнай трейд- 62, 63, 93, 94 дугаар шатахуун түгээх станцын байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, Цагаан-Үүр сумын төвд байрлах “Оюу” шатахуун түгээх станц, Галт сумын төвд байрлах “Их бадаат” ХХК-ны шатахуун түгээх станцын 2020 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөг хянан батлуулж ажилласан.

Шинэ чандмань ХХК, Сэлэнгэ жуулчны баазад ус ашиглуулах дүгнэлт гаргав. Аймгийн Засаг даргын 2020 оны 03 тоот албан даалгаврын хүрээнд Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх эргүүл постонд хилэнтийн гүүрэнд хуваарийн дагуу пост ажиллуулан, Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийж ажиллах талаар сумдад зөвлөмж чиглэл өгөх, цахимаар мэдээлэл өгч ажилласан.

Цэцэрлэг, Цагаан-Уул сумдад эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 2,га талбайд хийлгэсэн.Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Хатгал тосгоны иргэдийн мэдээллийн дагуу Нэмэх бадрал ХХК, Далайн давлагаа ХХК-ны үйл ажиллагаанд аймгийн МХГ, Цагдаагийн газар, Хөвсгөлийн улсын тусгай

хамгаалалттай газрын албан хаагчидтай хамтран хяналт шалгалтын ажил зохион байгуулж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Х.ГАН-ОЧИР

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА